

**Худалдаа, байгаль орчин,
тогтвортой хөгжил хоорондын
уялдаа холбоо**

2-р хэсэг

2017 оны 5 дугаар сарын 29

Сургалтын зорилго

- ХАА-н бүтээгдэхүүний ангилалтай холбоотой үндсэн нэр томъёо, тодорхойлолтуудын талаар мэдлэг олгох;
- Гол салбарууд дахь байгаль орчны бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэг олгох;
- Хөгжиж буй орнууд, Монгол Улс дахь худалдаа, ногоон эдийн засаг хоорондын уялдаа холбоог тайлбарлах.

Төлөвлөлт

- Хэсэг 1: Ногоон эдийн засгийн хөгжил, өнөөгийн төлөв байдал
 - ХАА-н салбар дахь ногоон худалдаа
 - Нэр томъёоны тодорхойлолт
 - Монгол дахь ногоон ажлын байрны төлөв байдал
- Хэсэг 2: Ногоон эдийн засгийн боломжийг тодорхойлох явц
 - Нийгэм эдийн засгийн ойлголт дахь үйл ажиллагааг суулгах аргачлал
 - Монгол Улсад хүртээмжтэй, ногоон эдийн засгийн концепцийг боловсруулах үндсэн асуудлууд
 - Тодорхойлж гаргаж ирсэн боломжуудад үнэлгээ өгөх
 - Санал болгож буй үйл ажиллагаанаас гарах үр дүн

Хэсэг 1: Ногоон эдийн засгийн хөгжил, өнөөгийн байдал

- ХАА-н салбар дахь ногоон худалдаа
- Нэр томъёоны тодорхойлолт
- Монголын ногоон ажлын байрны төлөв байдал

Ногоон буюу тогтвортой ХАА НУББОХ-ийн

Ногоон эдийн засгийн 2011 оны тайлан

Дараах үр дүнг авчрах газар тариалангийн салбарын практик үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга зам:

- Хүнс, экологийн үйлчилгээг тогтвортой байдлыг хангахын зэрэгцээ газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх;
- Хөрсний элэгдэл, ХАА, химийн органик бус бохирдол, ХАА-н гаралтай хүлэмжийн хийн ялгарал зэрэг сөрөг үр дагаврыг бууруулах;
- Хөрсний шим, ус, агаар болон биологийн олон янз байдал, тухайлбал амьтан, ургамлын генетикийн олон янз байдал зэрэг экологийн нөөцийг нөхөн сэргээх.

ХАА-н бүтээгдэхүүний ангилал

- Органик бүтээгдэхүүн
- Гэрчилгээжүүлсэн органик бүтээгдэхүүн
- Био бүтээгдэхүүн
- Шударга худалдааны гэрчилгээ/шошготой бүтээгдэхүүн

Органик ХАА (ОХААХОУХ-ны цахим хуудас)

Органик ХАА нь

- Хөрс, экосистем, хүн амын эрүүл мэндийг хангах үйлдвэрлэлийн систем,
- Орон нутгийн онцлог, нөхцөлд тохирсон, экологийн процесс, биологийн олон янз байдалд тулгуурласан байх,
- Сөрөг үр дагавартай үйл ажиллагаанаас татгалзах зарчмыг баримталсан,
- Уламжлал, инноваци, шинжлэх ухааныг хослуулдаг байх,
- Оролцогч бүх талуудын хоорондын шударга харилцааг дэмжсэн, амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн, нийтээрээ/хамтаараа ашиглах орчныг бүрдүүлсэн байх

ХАА-н гэрчилгээжүүлэлт

- Үйлдвэрлэгчид амьжиргаагаа дээшлүүлэх боломж олгох,
- Биологийн олон янз байдлыг хадгалах,
- Ажлын нөхцлийг сайжруулах.

ХАА-н стандартууд нь гэрчилгээжүүлэх **үндсэн** шаардлагуудыг хангасан байх,

- Нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөхцлийг сайжруулахад чиглэсэн **хөгжлийн** асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн байх.

ЕХ-ны шаардлага, түүний үзүүлэх НӨЛӨӨ

- ХАА-н органик бүтээгдэхүүний 90 хувийг ЕХ, АНУ хэрэглэдэг.
- ЕХ-нд мөрдөж буй нөхцлийн дагуу үйлдвэрлэсэн, хянан шалгасан ЕХ-ны гишүүн бус улсын органик бүтээгдэхүүнийг ЕХ-нд нийлүүлэх зөвшөөрлийг Европын Зөвлөлийн (ЕЗ) 834/2007 тоот захирамжаар олгосон.
- Үүнийг хоёр аргаар баталгаажуулж болно.
 - Европын комисс, ЕХ-ны гишүүн улсууд нь ЕХ-ны гишүүн бус улсад үйл ажиллагаа явуулж буй гэрчилгээжүүлэлт хийх байгууллагуудад эрх олгох.
 - ЕХ-той адил стандарттай хэмээн тооцогддог улсын жагсаалтад орсон ЕХ-ны гишүүн бус улс, эсвэл жагсаалтад ороогүй боловч хянан шалгах эрх бүхий зөвшөөрөгдсөн байгууллага нь бүтээгдэхүүнд гэрчилгээ олгох.
- Хөгжиж буй улс орнуудад адил төстэй дүрэм журам, хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой Давхар систем.

Шударга худалдааны гэрчилгээ

- Шударга худалдааны олон улсын байгууллага (ШХОУБ, FLO) нь ядуу улс орнуудын үйлдвэрлэгч, борлуулагчдыг бүхэлд нь хамарсан, ядуурлыг бууруулах, үйлдвэрлэгчдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилго бүхий стандартуудыг боловсруулсан.
- Шударга худалдаа нь дэлхий дахинд хамгийн өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны “шошго” болно.
- Шударга худалдааны хамгийн доод үнэ
 - Гэрчилгээжүүлсэн бараа бүтээгдэхүүн бүрийн доод үнэ
 - Шударга худалдааны хүрээнд борлуулагдсан бүтээгдэхүүн бүрийн “Шударга худалдааг хөгжүүлэх урамшуулал/шагнал”, боловсрол, эрүүл мэнд, нийт иргэдийн хөгжилд хөрөнгө оруулалт хийх

Балба улсын органик цай

- Орон нутгийн цайны компанитай түншлэлийн харилцаатай, цайны 131 жижиг тариаланчдын бүлгийг хамруулсан зүүн Балбын Сундерпанийн Цайны нөхөрлөл.
- Хөрс хамгаалах, үржил шим, бордоо, органик стандарт, гэрчилгээ олгох үйл явц, цайны навч хураах, тайлан мэдээллийг хадгалах зэрэг асуудлаар компани болон тариаланчдад техникийн тусламж үзүүлсэн.
- Чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд сургалт явуулж, 100 тариаланчдыг “сургагч багш бэлдэх” сургалтад хамруулсан.
- Германы түнш компани нь 53 тонн Балбын органик цайг “Сундерпанийн сэтгэлийн хүч” нэртэйгээр гадаадын зах зээлд борлуулсан.
- Тариаланчид ердийн цайны навчны дотоодын дундаж үнэтэй харьцуулбал даруй хоёр дахин илүү үнээр борлуулсан. Бага өртөгтэй, эдийн засгийн хувьд ашигтайнийгмийн болон байгаль орчинд ээлтэй санаачлаг байсан.
- Санаачилгын үр дүнд олон тариаланчид органик цайны үйлдвэрлэл эрхлэхийг хүсэв.

Гана улсын какаогийн тогтвортой газар тариалангийн аж ахуй

- Төслийн хүрээнд какаогийн тариаланчид, болон ард иргэдэд дараах тусламжийг үзүүлсэн. Үүнд:
 - какао үйлдвэрлэл ба байгаль орчны асуудлын хамарсан практик үйл ажиллагаа,
 - ойн тухай хууль, тогтоомж,
 - иргэдийн мод эзэмших эрх.
- Байгалийн нөөцийг ашиглах, үр шимийг хүртэх ард иргэдийн эрхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн “Олон нийтийн нөөцийн менежментийн бүс”-ийг (АИНМБ, CREMA) Асунафогийн хойд дүүрэгт байгуулах санаачилгыг хэрэгжүүлсэн. Үүнд орон нутгийн 36 хэсэг хамрагдсан.
- Төслийн хүрээнд 787,000 модны суулгацыг тариаланчдад тарааж, усан зам болон хамгаалалттай газрын дагуух бүсэд 8600 га ойн талбайг нөхөн сэргээв.
- Какаогийн модыг хэт их нарнаас халхлах, хуурай улиралд хөрсний чийгийг хадгалах мод суулгахыг тариаланчдад уриалав.
- Суулгасан мод нь нүүрс төрөгчийг шингээх арга болов.

Байгаль орчны бүтээгдэхүүн, үйлчилгээ

- БОБҮ-г ус, агаар, хөрсөнд учруулах хор нөлөөллийг хэмжих, урьдчилан сэргийлэх, хязгаарлах, бууруулах болон хог хаягдал, чимээ шуугиан, экосистемийн асуудлыг шийдвэрлэх арга хэрэгсэл хэмээн тодорхойлсон (ЭЗХАХБ, 2005 он).

Хүртээмжтэй ногоон эдийн засаг

- Хүлэмжийн хий, нүүрс төрөгчийг бага ялгарал багатай,
- Үр ашигтай, цэвэр үйлдвэрлэл
- Хэрэглээ, үр нөлөө нь бүгдэд хүртээмжтэй байх
- Тойргийн буюу циркуляр эдийн засаг бөгөөд хамтаар/нийтээр ашиглах, хамтын ажиллагаа, эв нэгдлийг эрхэмлэх, уян хатан байх, боломж, харилцан хамаарлын зарчимд суурилсан.


ХНЭЗ-ийн зорилгууд

- Нийгэм, эдийн засгийн гүйцэтгэлийн зэрэгцээ байгаль орчныг хамгаалах
- Байгаль орчинд ээлтэй боломжуудыг түгээн дэлгэрүүлэх замаар нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх

Ногоон ажлын байр

- Эдийн засгийн төрөл бүрийн салбарт ажлын байр бий болгох, энэ үйл явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар тогтвортой түвшинд барих нөхцлийг хангах

Ногоон ажлын байрны хүртээмж, нийгэм, байгаль орчны үзүүлэлтүүд



*Байгаль орчинтой холбоотой ажлын байр
Ногоон ажлын байр
Зохистой ажлын байр*

*Эх сурвалж: ХНЭЗ-ийн “Малайзийн ногоон
ажлын байрны 2013 оны зураглал”
судалгаа*

Байгаль орчны салбарын ажлын байр

Байгаль орчинд үзүүлэх дарамтыг бууруулах, устгах, байгалийн нөөцийг илүү үр өгөөжтэй ашиглахыг тэргүүлэх зорилт болгосон эдийн засгийн үйл ажиллагаа

– **Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа**

- Бохирдол болон байгаль орчны доройтлын бусад хэлбэрээс сэргийлэх, бууруулах, устгахыг тэргүүлэх зорилт болгох.

– **Нөөцийн менежментийн үйл ажиллагаа**

- Байгалийн нөөцийг хадгалан хамгаалах, зохистой ашиглах, улмаар устаж үгүй болохоос хамгаалахыг тэргүүлэх зорилт болгох.

ОУХБ-ын зохистой ажлын байрны хөтөлбөр

- **Ажлын байр бий болгох:**
 - Хөрөнгө оруулалт, бизнес эрхлэлт, ур чадварыг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, тогтвортой амьжиргааг хангах боломжийг бүрдүүлэх эдийн засаг.
- **Хөдөлмөрийн эрхийг баталгаажуулах**
 - Бүх ажилчид, ялангуяа ядуу болон эмзэг бүлгийн ажилчдын төлөөлөл, оролцоог хангах, тэдний ашиг сонирхлыг хуулиар хамгаалах.
- **Нийгмийн хамгааллыг өргөжүүлэх**
 - Хүртээмж болон үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх
 - Орлогоо алдсан, буурсан тохиолдолд түүнтэй тэнцэх хэмжээний нөхөн олговор олгох, эрүүл мэндийн зохистой үйлчилгээнд хамрагдах.
- **Нийгмийн яриа хэлэлцээр, зөвшилцлийг дэмжих**
 - Үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ажилчдын, ажил олгогчдын хүчирхэг байгууллагуудын оролцоо нэн чухал ач холбогдолтой.

Ногоон ажлын байр

Монгол Улсын зураглал. ОУХБ 2014 он

#	Sectors	Employment	Decent Jobs	Environment friendly Jobs	Green jobs	% Green Jobs
1	Animal husbandry	342,882	42,512	252,915	42,512	12.4
2	Construction	69,300	69,300	3,610	0	0
3	Transport	72,900	72,900	12,506	12,506	17.1
4	Crop production	58,477	20,932	4,591		0
5	Energy	14,500	14,500	1,231	1,231	8.5
6	Water, sewerage, water treatment	6,538	6,538	5,159	5,159	78.9
7	Forestry	3,923	3,923	3,923	3,923	100
8	Solid waste management	1,401	300	1,401	300	21.4
	Total (no)	569,921	230,905	285,336	65,631	11.5
	Share of employment		40.50%	50.00%	11.50%	

МАА-н салбарын ногоон ажлын байрны төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ

- Нийт ажиллагсдын 60 %
 - Ажлын байрны 73 % нь байгаль орчинд ээлтэй
 - Зохистой ажлын байрны эзлэх хувь бага, зөвхөн 12 % нь ногоон ажлын байр
- МАА-н салбарт анхаарах гол асуудал:
 - Малчид өөрсдийн бүтээгдэхүүнээс олох орлогыг нэмэгдүүлэх
 - Өндөр үр өгөөжтэй, дэлхийн үнэ цэнийн сүлжээнд малчдыг холбох
 - Малчдын амьдралын нөхцлийг амь зогоох хэлбэрээс ангижруулах
- Зохистой ажлын байрны хэлбэрээр ногоон эдийн засагт хувь нэмэр оруулах өндөр чадамжтай салбар

Барилгын салбарын ногоон ажлын байрны төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ

- Нийт ажиллагсдын 12.5 %-ийг эзлэх хэдий ч бүгд зохистой ажлын байр
- Эрчим хүчний ажлын байрны зөвхөн 5 % нь байгаль орчинд анхаарал хандуулсан
- Байгаль орчинд анхаарал хандуулсан ажлын байрны чадамж өндөр
 - Нүүрсний агууламж багатай, эрчим хүчний үр ашигтай зарцуулалттай байшин барилгын эрх зүйн, зохицуулалтын болон урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх
 - Ногоон барилга байгууламжийн салбарыг эко аялал жуулчлалтай холбох
 - Ногоон барилга байгууламжийн салбарыг ойн аж ахуйн салбартай холбох

Тээврийн салбарын ногоон ажлын байрны төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ

- Нийт ажиллагсдын 12.7 %-ийг эзлэх хэдий ч бүгд зохистой ажлын байр
- Эрчим хүчний ажлын байрны 17 % нь байгаль орчинд анхаарал хандуулсан
- Байгаль орчинд анхаарал хандуулсан ажлын байрны чадамж өндөр
 - Ард иргэд, хөрөнгө оруулалт, бэлэн бүтээгдэхүүний логистик нь ногоон эдийн засгийн бүх салбарт чухал ач холбогдолтой
 - Малчдыг сумын төвтэй холбоход цахилгааны хөдөлгөөнт эх үүсвэрийг ашиглах боломжийг судлах
 - Зорчигч, барааны тогтвортой тээвэрлэлтийг хангахад цахилгаан төмөр замын сүлжээг хөгжүүлэх

ХАА, газар тариалангийн салбарын ногоон ажлын байрны төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ

- Нийт ажиллагсдын 10.2 %: 4 дүгээрт орох том салбар
- Ажлын байрны зөвхөн 8 % нь байгаль орчинд анхаарал хандуулсан
- ХАА, газар тариалангийн үйлдвэрлэлд зохистой ажлын байр байхгүй
- ХАА, газар тариалангийн үйлдвэрлэл нь хүнсний аюулгүй байдлыг хангахад нэн чухал
 - Илүү тогтвортой арга техникийг нэвтрүүлэх шаардлагатай
 - Салбарыг чадамжтай, сонирхол татахуйц болгохын тулд урамшууллын системийг шинэчлэх шаардлагатай.

Эрчим хүчний салбарын ногоон ажлын байрны байдлын дүн шинжилгээ

- Нийт ажиллагсдын 2.5 %-ийг эзлэх хэдий ч бүгд зохистой ажлын байр
- Эрчим хүчний ажлын байрны зөвхөн 8.5 % нь байгаль орчинд анхаарал хандуулсан
- Байгаль орчинд анхаарал хандуулсан ажлын байрны чадамж өндөр
 - Хөдөө орон нутагт сэргээгдэх эрчим хүч, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар байгаль орчинд анхаарал хандуулсан ажлын байрны хувийг нэмэгдүүлэх
 - Цэвэр нүүрсний төслүүдийг хэрэгжүүлж, бохирдол, ялгаруулалтыг бууруулах
 - Дулааны их хэмжээний эрчим хүч ашигладаг байгууламж, өрхийн эрчим хүч ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх.


Усны татуур хоолой, ус цэвэршүүлэх салбарын ногоон ажлын байрны байдалд хийсэн дүн шинжилгээ

- Нийт ажиллагсдын зөвхөн 1.1 %
- Ажлын байрны 79 % хувь нь зохистой болон байгаль орчинд анхаарал хандуулсан
- Усны давхаргын нөөцийг хамгаалахад ус болон бохир усны салбар нэн чухал ач холбогдолтой
 - Эко аялал жуулчлалын үйл ажиллагааг ундны аюулгүй усаар хангах
 - Арьс шир, ноос үйлдвэрлэлийн салбар экологид ээлтэй арга хэлбэрийг ашиглах
 - ХАА-д хангалттай усны нөөц байгааг баталгаажуулах.

Ойн аж ахуйн салбарын ногоон ажлын байрны төлөв байдлын дүн шинжилгээ

- Нийт ажиллагсдын 1 хүрэхгүй хувь
 - Ажлын байр 100 % байгаль орчинд ээлтэй ба зохистой
- Ойн аж ахуй нь ногоон ажлын байранд бүх түвшинд хувь нэмэр оруулах боломжтой
- Гэрчилгээжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг экспортонд гаргах замаар тус салбар нь ногоон эдийн засагт хувь нэмэр оруулах өндөр чадамжтай
 - Тогтвортой ашиглах замаар ойн талбайг нэмэгдүүлэх
 - Ойн гэрчилгээг баталгаажуулах хөтөлбөрийн (ОГБХ, PEFC) дагуу баталгаажуулсан, орон нутгийн онцлог нөхцөлд тохирсон гэрчилгээг олгох
 - Тогтвортой мод бэлтгэлийг хөгжүүлэх зорилгоор нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн боловсруулан гаргах

Монгол Улсын ногоон ажлын байрны ерөнхий үзүүлэлт



Анхаарах асуудлууд

- МАА, ХАА, тариалангийн салбарт зохистой ажлын байр бий болгох
- Гол зах зээл дээр үйлчилж буй дэлхийн стандартад нийцсэн дотоодын гэрчилгээг боловсруулж, хүлээн зөвшөөрүүлж баталгаажуулах
- Малчид, тариаланчдад нийлүүлэлтийн сүлжээнээс шударгаар хувь хүртэхэд нь дэмжлэг үзүүлэх
- Ногоон эдийн засгийн салбар хоорондын харилцан уялдаа холбоо, зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашгийг нэмэгдүүлэх

Ногоон эдийн засгийн бодит кэйс

- Шинэ Зеландын мал аж ахуйн үйлдвэрийн туршлага нь Монголын хувьд судлах ёстой туршлага болж чадна.
- Перугийн Каму-Каму жимсний асуудал нь Монголын чацарганыхтай төстэй.
- Канадын дүнзэн байшингийн салбарын туршлагыг Монголын нөхцөлд нийцүүлэн ашиглаж болно.
- Оросын эко аялал жуулчлалтай төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээг Монголын нөхцөлд хөгжүүлэх боломжтой.

Шинэ Зеландын МАА-н салбар

- Эх сурвалж: МОУХӨК-ийн ХАА-н аж үйлдвэрийн тайлан, 2017 оны 1 дүгээр сар.
- Ноос, ноолууран бүтээгдэхүүнийг эс тооцвол Монголын МАА-н салбарын бүтээгдэхүүн гадаадын зах зээлд үндсэндээ нэвтрээгүй.
- Шинэ Зеланд нь 120 улсад 750,000 тонн мах экспортлож, 3.8 тэрбум ам долларын орлого олдог.
- Шинэ Зеландын хонь, үхрийн тоо толгой Монголынхтой адил.
- Шинэ Зеланд нь гол зах зээлээсээ алслагдсан.
- Шинэ Зеланд нь Монголын мал аж ахуйн салбарын төлөв байдалд харьцуулан дүн шинжилгээ хийх жишээ байж болно.

Перугийн Каму-Каму жимс

- Эх сурвалж: Ногоон эдийн засаг болон Худалдааны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 дугаар хэвлэл, 2016 оны 12 дугаар сар.
- **Каму-Каму (*Myrciaria dubia*) жимсний экспортыг нэмэгдүүлснээр амьжиргааны түвшинг дээшлүүлж, байгаль орчны хамгааллыг сайжруулсан.**



Зорилго, үр нөлөө

- Каму-Каму жимс нь Амазон мөрний нам дор сав газарт ургадаг.
- С витамин агуулгаар жүржээс 40 дахин илүү ба кальци, фосфор, төмөр, рибофлавин, ниацин, тиамин агуулдаг.
- Бал, царцмаг, чанамал, архи, дарс, бренди, цуу маягаар боловсруулдаг.
- Жимсийг тариалж дэлхийн зах зээлд зохистой үнээр нийлүүлэхээр төлөвлөсөн.
- Дотоодод нэн шаардлагатай орлогыг бүрдүүлэх, нам дор газрын эко системийг хадгалан хамгаалах эрмэлзлийг төрүүлэх давхар үр нөлөөтэй.

Үйл ажиллагаа, арга хэмжээ

- Баталгаатай зээл, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар үйлдвэрлэгчдийн санхүүгийн сонирхлыг дээшлүүлэх.
- Тогтвортой ургац хураах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулан гаргах, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрүүд болон төр-хувийн хэвшлийн түншлэл.
- Гадаадын зах зээлд нэвтрэх худалдааны түншлэлийг хөгжүүлэх.

Канадын дүнзэн байшин

- Эх сурвалж: Судлаачийн өөрийн судалгаа.
- Хойд Канадын хатуу модыг ашигладаг.
- 15 см-ийн зузаантай угсардаг дүнз.
- Ашиглалтад бэлэн дүнзэн байшин.
- Нүүрс төрөгч сийрэгжүүлэх боломжтой.
- Угсрахад бэлэн хэлбэрээр дэлхий дахинд экспортонд гаргадаг.

Дүнзэн байшин



Цул модон хийц



Цул модон хийц



Оросын эко аялал жуулчлал

- Эх сурвалж: Ногоон эдийн засаг болон Худалдааны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2 дугаар хэвлэл.
- Байгалийн унаган төрхийг хадгалахын зэрэгцээ адал явдалт болон эко аялал жуулчлалыг алслагдсан бүсүүдэд хөгжүүлж байна.
- Өргөн уудам нутагтай, хүн ам цөөнтэй, байгалийн унаган төрхтэй, үзэсгэлэнт нутаг.
- Оросын түүх, соёлын өв, байгалийн үзэсгэлэнт байдал жуулчдыг татаж байна.
- Аялал жуулчлалын компаниуд визийн журмыг хөнгөвчлөх хүсэлтийг ГХЯ-нд тавьсан.


Үндсэн зорилго

- Тогтвортой/ногоон/цэвэр технологийг нэвтрүүлэх, дамжуулах, аялал жуулчлалын салбарын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн менежментийг хэрэгжүүлэх замаар аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулах.
- Орон нутгийн ард иргэдэд дэд бүтцийг удирдах, жуулчлалтай холбоотой бизнес эрхлэхэд үүрэг хариуцлагыг ногдуулах.
- Адал явдалт болон эко жуулчлалын газруудыг танин мэдүүлэх, жуулчлалыг зохион байгуулах арга хэлбэрийн талаар ард иргэдэд боловсрол олгох.
- Бүс нутгийн түвшинд сафари, далайн эргийн жуулчлалтай өрсөлдөхүйц аялал зохион байгуулах чиглэлээр хамтран ажиллах боломжийг судлах.
- 2018 онд ОХУ-д зохиогдох хөл бөмбөгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг дэлхий дахинд эко жуулчлалыг хөгжүүлэх арга хэлбэр болгон ашиглах.

Асуултууд ?

Хэсэг 2: Ногоон эдийн засгийн боломж, түүнийг тодорхойлох үйл явц

- Нийгэм, эдийн засгийн төлөвлөлтөд тусгах аргачлал
- Монгол Улсад хүртээмжтэй ногоон эдийн засгийн концепцийг боловсруулах, хөгжүүлэх тулгуур асуудлууд
- Тодорхойлж гаргаж ирсэн боломжуудад үнэлэлт дүгнэлт өгөх
- Санал болгосон/сонгон авсан үйл ажиллагаанаас гарах үр дүн
- Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа



Туршилтын болон практик ажиллагаа, зах зээлийн төлөв байдал, ажиглагдсан алдаа дутагдал

- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хувьд төвлөрсөн эдийн засаг, бага нэмүү өртөгтэй бүтээгдэхүүн нь Монгол брэндийг хөгжүүлэхэд саад тотгор болсон
- Малчдын уламжлалт арга ажиллагаанд цаг агаарын онцгой нөхцлийн үзүүлсэн нөлөө, орлогын шударга бус хуваарилалт нь хот сууринд шилжих хөдөлгөөн, ядуурлыг нэмэгдүүлсэн
- Гадаадад ажиллаж буй монголчууд нь мөнгөн гуйвуулгаас илүүтэй, үнэ цэнэтэй, ашиглах боломжтой нөөцийн эх үүсвэр болно
- Дэлхий дахинд өрсөлдөх чадвартай эдийн засгийн салбарын хомсдлоос шалтгаалан боловсролтой хүн амын хөдөлмөр эрхлэлт хангалтгүй байна
- Ашигт малтмалын салбарыг эс тооцвол байгалийн нөөцийг эдийн засгийн хөгжилд хамгийн үр өгөөжтэй ашиглах үйл ажиллагаа дутмаг байна
- Хуучирсан барилга байгууламжид эрчим хүчийг үр ашиггүй зарцуулах нь хүлэмжийн хийн ялгарал, нүүрс төрөгчийн ялгаралт өндөр байх үндэс болж байна

Алсын хараа, стратеги, бодлого, эрх зүйн болон зохицуулалтын тогтолцоо, институци

- Улс төрийн дэмжлэг өндөр
- Төвлөрсөн эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих, худалдааг чөлөөлөх явц нь шаардлагатай орчин нөхцөл бүрдэхээс өмнө явагдсаны улмаас аж үйлдвэржилт саарч, мэргэжлийн үр чадвар буурах, алдагдах, импортод чиглэсэн үйл ажиллагаа илүү хөгжихөд хүргэсэн
- Ашигт малтмалын салбарт суурилсан эдийн засаг нь нэмүү өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхээс илүү түүхий эдийн экспортод шилжихэд хүргэсэн
- Худалдааны уламжлалт түншүүд, логистикийн тогтолцоо нь бүс нутгийн экспорт, хөрөнгө оруулалтад чиглэж, дэлхийн зах зээлийн нөөц, төрөлжсөн бараа бүтээгдэхүүнийг ашиглах боломжийг хязгаарласан
- Ногоон хөгжлийн шинэ загваруудыг бий болгох тогтолцоог боловсруулах
- Төвлөрсөн удирдлагатай эдийн засгаас татгалзсантай холбогдон үүссэн сул орон зайг бөглөх, ногоон эдийн засгийн санаачилгыг бодитоор хэрэгжүүлэхэд төр засаг, орон нутгийн байгууллага, мэргэжлийн болон үйлдвэрийн холбоод тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ.

Чиглүүлэх асуултууд

- Монголын мал маллагааны уламжлалт аргыг байгаль орчинтой зохицуулан, бизнесийн ногоон ажлын байр бий болгоход чиглүүлэн, дэлхийд өрсөлдөх чадвартай үйл ажиллагаанд шилжүүлэх ямар арга зам байж болох вэ?
- Монгол Улсын нөөцөд тургуурлан байгаль орчны ямар бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийд өрсөлдөх чадвартай ногоон бүтээгдэхүүнийг болгон төрөлжүүлж, үйлдвэрлэх боломжтой вэ?
- Монгол Улсын өрсөлдөх чадварыг сэргээх, ажилгүйдэл, гадаадад гарах, ядуурал, нийгмийн ялгавартай байдал, байгаль орчны доройтол зэрэг сөрөг хандлагыг бууруулахад ногоон эдийн засгийн санаачилгууд ямар хувь нэмэр оруулах вэ?

Анхдагч салбарт суурилсан брэндийн санаачилга

- Дэлхийд өрсөлдөх чадвартай органик эрүүл хоол хүнс, эко аялал жуулчлал, ноос, савхины босоо тэнхлэгтэй, цогц, тогтвортой/ногоон эдийн засгийн салбарууд, ойн аж ахуйн тогтвортой бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжсэн Монгол брэндийн мастер төлөвлөгөөг боловсруулах
- Малчдад мал сүргийг байгаль орчинтой зохицуулан тогтвортой өсгөх, санхүүгийн үр ашигтай, тэгш байдлыг бий болгох, эко аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх боломжийг хангах эрх зүйн зохицуулалт, урамшууллын механизмийг бий болгох
- Мах, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, хадгалах хувийн төвүүдийг сумдад байгуулах, малчдад үзүүлэх үйлчилгээг өрсөлдөөний зарчмаар явуулах зэргээр хөдөө орон нутгийг хөгжүүлэх

Нэмүү өртөгтэй брэндийн бараа үйлдвэрлэл

- Монголын савхийг Эко савхины гэрчилгээний стандартын дагуу боловсруулах, брэндийн савхин эдлэл үйлдвэрлэх эрх зүйн зохицуулалт, урамшууллын тогтолцоог бий болгох
- ОГБХ-өөр баталгаажуулсан нэмүү өртөгтэй бүтээгдэхүүн, тухайлбал дүнзэн байшинг дэлхийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэх, гэрчилгээтэй, тогтвортой мод бэлтгэлийн эрх зүй, зохицуулалт, урамшууллын тогтолцоог бий болгох
- Ноос, ноолуурын салбарт хуримтлуулсан туршлага, үндэсний хэв загварын гоёмсог бүтээгдэхүүн үйлдвэрлэлд үндэслэн нийлүүлэлтийн цогц, нэгдсэн сүлжээг байгуулах

Анхдагч, хоёрдагч болон үйлчилгээний салбар хоорондын холбоог бүрдүүлэх

- Нутгийн үүлдрийн, бэлчээрийн малын Omega 3-аар баялаг, өвөрмөц агуулгатай мах болон сүүн бүтээгдэхүүнд үндэслэн эрүүл хоол хүнсний салбарыг хөгжүүлэн, бүтээгдэхүүнийг аялал жуулчлалын салбар болон дэлхийн зах зээлд борлуулах.
- Чацарганы эрүүл мэндэд үзүүлэх эерэг нөлөөллийн судалгаа, шинжилгээ, боловсруулалтыг гадаадын судалгааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх хамтын ажиллагааг хөгжүүлэх, чацарганы орон нутгийн гэрчилгээт бүтээгдэхүүний стандарт бий болгох.
- Нүүдлийн соёл иргэншил, эрүүл хоол хүнс, өвөрмөц амьдралын хэв маяг, үзэсгэлэнт унаган байгаль, орон нутгийн бүтээгдэхүүнд үндэслэн адал явдалт болон байгалийн аялал жуулчлалын онцлог хэлбэр, эко жуулчлалыг жилийн 4 улиралд хөгжүүлэх.

Хүлээгдэж буй бодит үр дүн

- Үндэсний бүтээгдэхүүний чанар, үнийг тогтоох, гадаад болон дотоодын зах зээлд өргөнөөр нэвтрүүлэх замаар Монгол бүтээгдэхүүний төрөл, брэндийн нэр хүндийг бэхжүүлэх.
- Дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд нэгдэн оролцсоны үр шимийг хүн амын олонхи тэгш хүртэх нөхцлийг хангасан, шударга нийгэмд сайхан амьдрах нөхцлийг хангах.
- Мал сүрэг, ХАА-г цаг агаарын онцгой байдлаас хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд уян хатан хандах, инновацийн замаар хүнсний үйлдвэрлэлийн системийг бүрдүүлэх.

Хүлээгдэж буй бодит үр дүн

- Эрчим хүчийг үр ашигтай зарцуулах орчин, тогтвортой хот төлөвлөлт, тогтвортой тээвэр нь нүүрс төрөгч бага ялгаруулдаг эдийн засгийг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт олон талт эерэг нөлөө үзүүлнэ.
- Боловсролтой ажиллах хүчин, мэдлэг, ур чадвартай ажилчдыг инновацийн төслүүдэд татан оролцуулж, орон нутгийн асуудлуудыг зохистой шийдвэрлэх.
- Гадаадад амьдарч байгаа, бизнесийн туршлагатай хүмүүс нь нутгийн хүмүүстэй түншлэн, ногоон эдийн засгийн салбарт ирээдүйтэй жижиг болон дунд бизнес, үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

Алсын хараа, стратеги, бодлого, эрх зүй, зохицуулалт, инститүцийг сайжруулсанаар гарах үр дүн

- Улс төрийн дэмжлэг нь хүн амын олонхийн (пирамидийн суурь, BOP) өдөр тутмын амьдралыг сайжруулах бодит үр дүнд хүргэнэ.
- Ногоон эдийн засгийн салбарт хуримтлуулсан орон нутгийн чадавхи, туршлагад суурилсан үйлдвэржилтийн бодлого нь хотын ажиллах хүчний томоохон хэсгийг ногоон ажлын байраар хангахад эерэгээр нөлөөлнө.
- Эмзэг бүлгийнхнийг тогтвортой амьжиргаатай болоход төр засгийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дэмжлэг үзүүлнэ.

Алсын хараа, стратеги, бодлого, эрх зүй, зохицуулалт, институтцийг сайжруулсанээр гарах үр дүн

- Үндэсний брэндийг хөгжүүлэх санаачилга нь Монгол Улсыг дотоодын, бүс нутгийн эдийн засагт бус, дэлхийд өрсөлдөхүйц бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болоход чиглэнэ.
- ДХБ-ын зарчим нь үндэсний хэмжээнд үүсч бий болж буй салбаруудыг дэлхийд өрсөлдөх чадвартай болтол нь тэтгэн хамгаалах зорилготой.
- Нөөцөөс хамааралтай эдийн засгаас нэмүү өртөг, мэдлэг, үйлчилгээнд суурилсан эдийн засагт шилжих.

Монголын нэмүү өртөгтэй өвөрмөц бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнд суурилсан үндэсний брэндийг хөгжүүлэх

- Монголын брэндийн мастер төлөвлөгөөг боловсруулах.
- МАА, ХАА-н гаралтай, дэлхийд өрсөлдөх чадвартай органик эрүүл хүнсний үйлдвэрлэлд анхаарах.
- Босоо тэнхлэгтэй, цогц, тогтвортой, нэмүү өртөгтэй салбаруудыг хөгжүүлэх
 - Ноос, ноолуур
 - Савхин бүтээгдэхүүн
 - Тогтвортой ойн аж ахуйн бүтээгдэхүүн
- Эко аялал жуулчлалыг үндэсний гол брэнд болгох

Малчдыг эдийн засгийн суурь нэгж болгон эрх мэдлийг нэмэгдүүлэх

- Малчдын үйл ажиллагааны эрх зүй, зохицуулалт, урамшууллын тогтолцоог шинэчлэх.
- Шүлхий өвчнийг устгахад малчдыг бүрэн татан оролцуулах.
- Цахилгаан, халаалт, ундны ус, нүүдлийн ахуй амьдрал, орчинтой холбоотой малчдын хэрэгцээг тогтвортой хангах технологийн шийдлийг тодорхойлох.
- Мал сүргийг онцгой хүйтэн цаг агаараас хамгаалах халхавч, өвөлжөө байгуулах.
- Эко жуулчлалыг малчдын орлогыг нэмэгдүүлэх давхар урамшуулал болгох.
- Малчдын бүтээгдэхүүнийг шударга худалдаанд хамруулах үйл ажиллагааг хөгжүүлэх.
- Малчдад мал сүргийг байгаль орчинтой нийцүүлэн тогтвортой өсгөх, санхүүгийн үр ашигтай, тэгш байдлыг бий болгох, эко аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх боломжийг хангахад дэмжлэг үзүүлэх.

Монголын хөдөө орон нутгийг нэмүү өртгийн тусгай төвүүдийн тусламжтайгаар сэргээх

- Сум дахь төвүүдийг хувийн мэргэжлийн баг удирдана.
- Нүүдлийн амьдралтай малчид, хот суурин газар оршин суугчдын хооронд логистикийн уялдаа холбоог бий болгох.
- Орон нутгийн үүлдрийн малын шинэ сүүг орон нутгийн хэрэглээ болон экспортын зориулалтаар боловсруулах.
- Нядалсан малын махыг хотын оршин суугчдын хэрэглээ болон экспортын зориулалтаар хадгалах зоорь байгуулах.
- Органик болон бэлчээрийн мал сүрэгт нийцсэн хамтын техник хэрэгсэл, мал маллагааны орчин үеийн менежментийн арга ажиллагааг нэвтрүүлэх.

Мэргэжлийн болон мэргэжлийн бус хот, суурин газрын ажилчдыг ажлын байраар хангах эко савхи боловсруулах, үйлдвэрлэх үйл ажиллагаа

- Эко савхин бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн эрэлт нэмэгдсэн.
- Дотоодын арьс ширийг түүхийгээр нь экспортлохын оронд боловсруулж нэмүү өртөг шингээх.
- Дотоодын үйлдвэрлэлийг түүхий эдээр байнга хангах, үйл ажиллагааг өвлийн улиралд идэвхжүүлэх.
- Гар аргаар нядалсан малын эко савхийг үндэсний нэг брэнд болгох

Мод бэлтгэлийг гэрчилгээтэй болгох, тогтвортой орчин бүрдүүлэх замаар монголын ойн үнийн ЖИШИГ ТОГТООХ

- Нэмүү өртөгтэй, тогтвортой мод бэлтгэлийн эрх зүй, зохицуулалт, урамшууллын тогтолцоог бүрдүүлэх.
- Монголын хойд хэсгийн ойн ургах хугацаа богино байдаг тул илүү нягтралтай.
- Ойн тогтвортой менежмент нь мод бэлтгэлийг хязгаарлан, нүүрс төрөгчийг сийрэгжүүлэх үүднээс модоор байшин барилга барих сонирхол сэргэж байгаад сөргөөр нөлөөлж болзошгүй.
- Монголын модыг ОГБХ-аар баталгаажуулах нь дэлхийн зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлнэ.
- Нэмүү өртөг шингэсэн дүнзэн байшин үйлдвэрлэж, дэлхийн зах зээлд нийлүүлэх нь өрсөлдөх чадвартай байж болзошгүй.

Өнөөгийн суурь нөхцөл, нөөцөд тулгуурлан ноос, ноолуурын цогц аж үйлдвэр байгуулах

- Цаг агаарын байдлаас шалтгаалан ноос, ноолууран чанартай бүтээгдэхүүн ямагт өндөр эрэлт, хэрэгцээтэй байна.
- Ноос, ноолууран бүтээгдэхүүний сүлжээнд Монгол Улс төдийлөн хамрагдаагүй.
- Интеграцийг хөгжүүлэх, брэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөрөнгө оруулалтыг дэмжих тогтолцоог бүрдүүлэх.
- Амьтны гаралтай мяндасны цогц аж үйлдвэрийг дэмжих дотоодын бүтээгдэхүүн, загварыг боловсруулах.

Монголд эрүүл хүнс боловсруулах салбарыг хөгжүүлэх

- Бэлчээрийн малын Omega 3-аар баялаг, өвөрмөц агуулгатай мах болон сүүн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулах.
- Нутгийн уугуул үүлдрийн малыг Онцгой худалдааны жагсаалтад оруулах.
- Эко аялал жуулчлалын салбарыг дэлхийн зах зээлд гаргахаар төлөвлөсөн эрүүл хүнсний туршилтын суурь болгох.
- Бүтээгдэхүүнийг хамгаалахад Газар зүйн заалтыг боломжийн хэрээр ашиглах.

Чацарганы бүтээгдэхүүнийг худалдааны зорилгоор үйлдвэрлэх

- Чацарганы эрүүл мэндэд үзүүлэх эерэг нөлөөллийг гадаадын судалгааны байгууллагуудтай хамтран судлах.
- Чацарганы бүтээгдэхүүнийг худалдааны зорилгоор үйлдвэрлэх асуудлаар судалгаа, боловсруулалт хийх.
- Чацарганы эмчилгээний клиникийн туршилт хийх.
Чацарганы гэрчилгээт бүтээгдэхүүний дотоодын стандартыг бий болгох.
- Монголын чацарганы газар зүйн заалтыг тодорхойлох.

Монголын брэнд эко аялал жуулчлалыг хөгжүүлэх

- Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн ард иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилготой, байгалийн хариуцлагатай аяллыг эко жуулчлал гэнэ.
- Жилийн 4 улиралд үйл ажиллагаатай эко аялал жуулчлалыг зохион байгуулах.
- Хурдтай хөгжиж буй адал явдалт болон байгалийн аялал жуулчлалд анхаарал хандуулах.
- Дараах нөхцөлд үндэслэн онцгой, өвөрмөц сэтгэгдэл төрүүлэх:
 - Нүүдлийн уламжлалт соёл, зан заншил,
 - Эрүүл хүнс,
 - Амьдралын идэвхтэй хэв маяг,
 - Үзэсгэлэнт унаган байгаль,
 - Монголын брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрийн үнээр борлуулах.
- Эко жуулчлалыг МАА, ХАА, барилга, тээвэр, эрчим хүч, ус, ойн аж ахуйн салбар хоорондын уялдааг бэхжүүлэхэд ашиглах.

Хэлэлцүүлгийн 5 салбар бүлэг

1. МАА-н бүлэг

- Мах, сүүн бүтээгдэхүүн
- Арьс шир, савхины салбар
- Ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүн

2. ХАА-н бүлэг

- Чацарганы бүтээгдэхүүн
- Нэмүү өртгийн бүтээгдэхүүн

3. Ойн аж ахуйн салбар

- Гэрчилгээт мод бэлтгэл
- Нэмүү өртгийн бүтээгдэхүүн

Хэлэлцүүлгийн 5 салбар бүлэг

4. Тогтвортой эрчим хүчний салбар

- Хөдөө орон нутагт нарны эрчим хүчийг хөгжүүлэх
- Дээврийн нарны эрчим хүч үүсгүүрийг цахилгаан сүлжээнд холбох
- Нарны эрчим хүчний станцын хүчин чадал
- Малын бууцнаас био хий гаргах

5. Эко аялал жуулчлалын салбар

- Байр, зочид буудлын чадавхийг нэмэгдүүлэх
- Бусад салбаруудтай холбоо тогтоох

Бүлгийн ажлыг зохион байгуулах санал

- Бүлэг бүрийн үйл ажиллагааны баримт бичгийг боловсруулахад НЭЗҮАТ-ийн үзүүлэлтийг ашиглах.
- Тодорхойлсон боломжуудад үндэслэн салбарыг ХНЭЗ-ийн хандлагад шилжүүлэх үйл ажиллагааг тэмдэглэх.
- Бодлогын загварыг боловсруулахад мэдээ мэдээллийг ашиглах.

НЭЗҮАТ-ийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтийн хамаарал	Үзүүлэлтийн төрөл	Монгол Улсын тухайн салбарын өнөөгийн нөхцөл байдал
Ногоон бодлого	Хууль журам Хөрөнгө оруулалт Эдийн засгийн бусад арга хэрэгсэл Судалгаа, хөгжлийн санхүүжилт	
Эдийн засгийн үйл ажиллагаа	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл Хөдөлмөрийн орлого Байгаль орчны бүтээгдэхүүн	
Байгаль орчны үйл ажиллагаа	Ундны усны чанар Газрын чанар Хөрсний элэгдэл Агаарын ялгаруулалт Биологийн олон янз байдал	
Нийгмийн ажиллагаа	үйл Хөдөө орон нутгийн хөгжил Хөдөө орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлт Хүний нөөц Нийгмийн нөөц Орлогын хуваарилалт	

ХНЭЗ-ийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Үзүүлэлтийн хамаарал	Үзүүлэлтийн төрөл	Салбарыг ХНЭЗ-ийн хандлагад шилжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа
Ногоон бодлого	Хууль журам Хөрөнгө оруулалт Эдийн засгийн бусад арга хэрэгсэл Судалгаа, хөгжлийн санхүүжилт	
Эдийн засгийн үйл ажиллагаа	Бүтээгдэхүүний үйлдвэрлэл Хөдөлмөрийн орлого Байгаль орчны бүтээгдэхүүн	
Байгаль орчны үйл ажиллагаа	Ундны усны чанар Газрын чанар Хөрсний элэгдэл Агаарын ялгаруулалт Биологийн олон янз байдал	
Нийгмийн үйл ажиллагаа	Хөдөө орон нутгийн хөгжил Хөдөө орон нутаг дахь хөдөлмөр эрхлэлт Хүний нөөц Нийгмийн нөөц Орлогын хуваарилалт	

Асуулт ?